



*The **AMERICAN CHAMBER** of Commerce in Mongolia*

ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ БА ЦАХИМ ЭДИЙН ЗАСАГ **БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ**

2020 оны 10 дугаар сар, Улаанбаатар

Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам) Мэдээллийн технологи, цахим эдийн засгийн хороогоороо дамжуулан энэхүү бодлогын баримт бичгийг боловсруулсан. Бодлогын баримт бичгийг бүтнээр, эсвэл хэсэгчлэн дахин хэвлэхэд АмЧам-аас зөвшөөрөл авна.

Зохиогчийн эрх © Монгол дахь Америкийн Худалдааны Танхим



Оршил

Эрх баригчид болон хөгжингүй улс орнууд шинжлэх ухаан, технологи, инновац (STI) нь эдийн засаг болон нийгмийн хөгжилд гол хүчин зүйлүүд гэж тодорхойлдог. Азийн орнууд дунд эдийн засагт нь хамгийн их өсөлт гарсан орнууд нь STI-г нийгмийн болон эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй урт хугацаанд уялдуулж, бодлогын шийдвэр гаргах түвшинд нэгтгэсэн орнууд байсан. Харамсалтай нь Монгол Улс энэ практикийг баримталдаггүй, үүний үр дүнд эдийн засгийн өсөлт нь бүс нутгийн хөгжлөөс хоцорсоор байна.

Мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)-ийн хөгжлийн хурд болон Ковид-19 цар тахлын улмаас бизнесийн орчин тогтмол өөрчлөгдөж буй энэ нөхцөл байдалтай уялдуулан АмЧам Монгол нь 2020 оны 6-р сард Мэдээллийн технологи, цахим эдийн засгийн хороог (МТЦЭЗХ) байгуулсан. МТЦЭЗХ нь мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)-ийн дэд бүтэц, үйлчилгээний хөгжлийг урагшлуулах, МХХТ-ийн хэрэгжихүйц бодлого, журмыг боловсруулах, хамтын ажиллагаа, мэдээллийн солилцоог дэмжин ажиллана. МХХТ-ийг үр дүнтэй ашиглаж, нийгэм, эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, бизнесүүдийн хувьд МХХТ-ийн аюулгүй, итгэж болох орчныг бүрдүүлэх зорилготой. Энэхүү хороо нь МХХТ-ийн тэргүүлэх компаниудын удирдлагуудаас бүрдэх бөгөөд Монгол улсын бизнесийн орчинг илүү сайжруулах талаар бусад салбарын бизнесийн удирдлагуудтай санал бодлоо байнга солилцоно.

Шинээр бүрдсэн УИХ болон Засгийн газар Инноваци, цахим бодлогын байнгын хороог байгуулах, “Цахим Монгол” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх замаар төрийн үйлчилгээг цахимжуулахаар төлөвлөж байна. Иймд АмЧам Монгол болон шинээр байгуулагдсан МТЦЭЗХ-ийн хувьд төр засгийн энэхүү санаачлагуудыг өөрсдийн туршлага, нөү-хауг хуваалцах замаар манлайлан ажиллах олон боломжууд байна.

Цахим шилжилт ба эдийн засаг

Цахим шилжилт гэдэг нь хувьсан өөрчлөгдөж буй бизнес, зах зээлийн хэрэгцээ, шаардлагуудад нийцүүлэхийн тулд цахим технологиудыг ашиглан шинэ бизнес процесс, соёл, үйлчлүүлэгчийн сэтгэгдлүүдийг бүтээх, эсвэл өөрчлөх үйл явцыг хэлнэ.

Цахим шилжилт гэдэг нь бизнес хийдэг арга замыг өөрчлөх, тэр байтугай зарим тохиолдолд бүр цоо шинэ төрлийн бизнесийг бий болгох явдал юм. Цахим шилжилтийн улмаас компаниуд нэг алхам ухарч, дотоод системээсээ авахуулаад хэрэглэгчидтэй цахимаар болон нүүр тулан харилцаж буй үйлчилгээ зэрэг өөрсдийн хийдэг бүх зүйлийг эргэн харж байна. Тэд шийдвэр гаргалт, “тоглоомын дүрмийг” өөрчлөхүйц үр ашигтай байдал, эсвэл хэрэглэгчиддээ хүрсэн илүү дээр үйлчилгээг үзүүлэхийн тулд бид бизнес процессоо хэрхэн өөрчилж болох вэ? гэдэг том асуултуудыг өөрсдөөсөө асууж байна.

Цахим эдийн засаг нь МХХТ-ийн хөгжлийн улмаас бизнесийн бүхий л секторууд бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэж байна. Эдийн засгийн цахим шилжилт нь бизнесүүд ямар зохион байгуулалттай байдаг, хэрэглэгчид хэрхэн бүтээгдэхүүн, үйлчилгээ болон мэдээлэл авдаг, төр засаг энэхүү хууль эрхзүйн шинэ сорилтод хэрхэн дасан зохицох талаарх өмнөх тогтсон ойлголтуудыг бүхэлд нь өөрчилж, хэлбэршүүлж байна.

Цахим шилжилт нь бизнесийн орчинг хялбар, илүү ил тод, хямд төсөр болгоно. Тиймээс цахим шилжилтийн ачаар ажлын байр нэмэгдэж, бизнес процессууд илүү ил тод болж, байгаль орчинд илүү ээлтэй ногоон эдийн засагтай болох зэрэг эдийн засгийн маш олон боломжууд гарч ирж байна. Бизнесийн бүхий л сегментүүдэд МХХТ болон цахим хөгжлийг ашигласнаар хүмүүсийн өдөр тутмын амьдрал, тухайлбал гэртээ бага насны хүүхдүүдээ харж буй ээж нар, алслагдсан бүс нутагт амьдарч буй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс г.м илүү хялбар, тав тухтай болж байна. Цахим шилжилт нь алслагдсан, ажилгүйдэл ихтэй хөдөө орон нутаг болон хүн ам ихтэй, автомашины түгжрэлийн асуудалтай нийслэл Улаанбаатар хотын хөгжил, цааашилбал Монгол улсын тогтвортой хөгжилд маш чухал юм.

Урьд нь Монгол улсын МХХТ-ийн салбарт төр болон хувийн хэвшлийн зүгээс олон чухал санал санаачлагууд гарч байсан бөгөөд бид энэ шинэ засгийн газрын үед дорвитой ахиц дэвшил гарна хэмээн найдаж, дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг санал болгож байна. Үүнд:

- а) Ковид-19 цах тахлын улмаас бизнес загварууд хурдан өөрчлөгдөж буй энэ үед МХХТ, **харилцаа холбооний сүүлийн үеийн технологиудыг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг цахимжуулах.** Цар тахлын хор уршиг, тархалтыг зогсоож, шийдвэрлэхийн тулд засгийн газар технологийн компаниудтай хамтран ажиллах хэрэгтэй. Үйлчилгээний болон боловсролын салбарын хувьд зарим нэг цахим платформууд болон загварууд нь эдийн засгийн уналтыг зогсооход ашиглагдаж болох юм. Бид засгийн газрыг технологийн компаниудаас тусламж авч, хамтран ажиллахыг санал болгож байна.

- b) **Мэдээллийн технологийн боловсролд зоригтой хөрөнгө оруулалт хийх** - Монгол компаниуд байгаа хэдий ч олон улсад бэлтгэгдсэн инженерүүд дутагдаж байна. Аливаа өөрчлөлт шилжилт амжилтанд хүрэхэд ойролцоогоор 70-80 хувь нь хүнээс хамааралтай байдаг. Бид STEM-ийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн боловсролын стандартуудыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Цахим Монгол г.м. үндэсний хэмжээний шилжилтийг хийхийн тулд Монгол улс иргэдээ, тухайлбал иргэдэд үйлчилгээ үзүүлдэг төрийн албаны ажилтнуудаас авахуулаад нөгөө талд нь үйлчлүүлж буй иргэдээ бүх төвшинд сургаж, боловсруулах шаардлагатай. Цахим шилжилтийн зорилго нь иргэн бүрт ялгаваралгүйгээр хурдан, найдвартай, үр дүнтэй үйлчилгээ үзүүлэх явдал учраас Монгол улс иргэдийнхээ цахим боловсролын түвшинг чухалчлан авч үзэх ёстой.
- c) **Дэд бүтцийн болон МХХТ-той холбоотой хуулиудыг нэг төрийн байгууллагын эрх мэдэл дор зангидах.** Одоогоор дангаар нь бүрэн хариуцсан байгууллага байхгүй байна. Харилцаа холбооны компаниуд зах зээлээ өөрсөддөө хадгалж, дохио хуваалцахгүй, менежментийн бодлогогүйгээр бараг л олигополийн зах зээл болгон хувиргадаг. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн давтамжийн менежментийн стандарт, лицензүүдийг ашигладаггүй,
- d) **Банк, банк бус санхүүгийн байгууллагууд, бусад салбарыг олон улсын дата төвүүд болон cloud платформуудыг ашиглахыг зөвшөөрөх.** Эдгээр нь илүү хямд байдаг ба Монгол улсын хуулиар одоогоор зөвхөн дотоодынхыг ашиглахыг зөвшөөрдөг. Энэ нь инновацийг үндэсний үйлчилгээ үзүүлэгчид болон тэдний хэрэглэгчдээс хааж буй явдал юм.
- e) **KYC ба AML-ийн нүүр нүүрээ хардаггүй технологийг зөвшөөрөх:** Цар тахлын улмаас иргэд тусгаарлалтанд орж, гацаж байгаа энэ үед банкны алсын зайны үйлчилгээ маш чухал үүрэгтэй. Ковид-19 цар тахлын дараагийн давалгаа бидэн дээр ирлээ хэмээн төсөөлөхөд банкны салбарын гадна дугаарлан зогсож буй тэтгэврийн иргэдийн хувьд банкны энэ үйлчилгээг гэрээсээ хөдөлгөөнт шийдлээр дамжуулах авах хэрэгтэй. Гадаадын олон хөрөнгө оруулагчид монгол компаниудад хөрөнгө оруулахдаа өөрсдийн албан ёсны нэрээр банкинд данс нээлгэх хэрэгтэй байдаг. Хөрөнгө оруулагчдийн хувьд банкинд данс нээлгэхдээ Монгол улсад байнга оршин суух эрх авах шаардлагатай болдог. Хэрэв KYC and AML технологийг зайнаас ашиглахыг зөвшөөрвөл, цар тахлын улмаас ямар нэг хориг тавигдсан ч нэлээн хэмжээний гадаадын хөрөнгө оруулалтыг эх орондоо хүлээн авах боломжтой. Энэ технологи нь ирээдүйн гарааны олон компаниудыг гадаад зах зээлд нэвтрэхэд туслах юм. Бүхий л технологи байдаг боловч цаг үеэсээ хоцорсон хуулийн улмаас эдгээр технологийг ашиглах боломжгүй байна. Ялангуяа цар тахлын энэ үед хамгийн их хэрэгцээтэй үйлчилгээ нь санхүүгийн үйлчилгээ бөгөөд олон хүмүүс эдгээр үйлчилгээнд хамрагдах боломжгүй байна. Түүнчлэн бүх зүйл олон улсын стандартад шилжвэл, бусад банк, улс орнууд Монголын банкуудын бүртгэл, тооцоог дижитал хэлбэрээр хүлээн авч, саарал жагсаалтад орох эрсдлийг бууруулж чадна.

- f) **Энэ салбарт sandbox-г эхлүүлж, тогтвортой хөгжүүлэх:** Sandbox гэдэг нь финтек гарааны компаниуд болон бусад шинийг санаачлагчдад хуулийн байгууллагын зааварчилгаа дор хяналттай орчинд жинхэнэ туршилт хийх боломжийг олгодог хууль эрхзүйн орчин юм. Энэхүү туршилтын хууль эрхзүйн орчин нь fintech салбарын амжилтанд чухал ач холбогдолтой бөгөөд хөгжиж буй оронд инновацийн хөдөлгөгч гол хүчин зүйл байдаг. Одоогийн байдлаар 32 улс туршилтын эрхзүйн орчинг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд араас нь 11 улс энэхүү хууль эрхзүйн орчинг хэрэгжүүлж эхлэхээ албан ёсоор зарлаад байна. Зарим улс орнууд энэхүү хууль эрхзүйн орчинг амжилттай туршсаны үр дүнд одоогийн журам, лицензийн шаардлагыг өөрчлөх тухай хуулийн төслийг боловсруулж эхлэв.

Одоогийн байдлаар Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) fintech байгууллагууд болон Монголын Финтек Холбооны гишүүдтэй хамтран Монгол Улсад энэхүү туршилтын хууль эрхзүйн орчин хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийн төслийг боловсруулсан. Илүү сайн үйлчилгээ, бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэхийн тулд fintech компаниуд СЗХ, Монгол банкнаас албан ёсны зөвшөөрөл авах шаардлагатай.

Арабын нэгдсэн эмират улс зэрэг орнууд Fintech-ийг хөгжүүлэх асуудлыг нэн тэргүүнд тавьж байна. Тэд Тэдний Fintech Sandbox нь технологийн салбарт хамгийн оновчтой байрлалд байдаг юм. Дубайн стратеги бол ур чадвараа сан болгон бүс нутагтаа нэвтрэх замаар fintech инновацыг хөгжүүлэх юм. Тэд хатуу журам, лиценз нь ямар ч шинэчлэл хийх орчин бүрдүүлэхгүй гэсэн байр суурьтай байдаг. Мөн уламжлалт банкны систем нь уян хатан биш ба Ковид-19 тахал зэрэг нөхцөл байдалд хангалттай хурдан биш байна гэж үзэн уян хатан хурдан дасан зохицох чадвартай fintech салбарт тулгуурлаж ажиллаж байна.

- g) **Open banking буюу Нээлттэй банкны үйчилгээ:**

Нээлттэй банкны үйчилгээ гэдэг нь санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг гуравдагч этгээд банк болон банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн гүйлгээ болон дата системд application programming interfaces (APIs)-ыг ашиглан нээлттэй нэвтрэх эрх олгодог банкны үйлчилгээ юм. Нээлттэй банкны үйлчилгээ нь хэрэглэгчид, санхүүгийн байгууллагууд болон гуравдагч үйлчилгээ үзүүлэгч этгээдэд данснууд болон датаг хооронд нь холбох боломжтой болгодог. Энэ нь банкны салбарын ирээдүйг шийдвэрлэх гол инновац болж байна. Товчхондоо, нээлттэй банкны үйлчилгээ нь Монгол улсад банкууд болон финтек компаниудын хоорондын хамтын ажиллагаа болон хөгжилд маш чухал юм. Энэхүү хамтын ажиллагаа болон үйлчилгээг Монгол улсад нэвтрүүлэхийн тулд төрийн байгууллагууд энэхүү үйлчилгээний зорилго, үр ашгийг нь сайтар ойлгох шаардлагатай.

h) **МХХТ болон Цахим Эдийн Засгийн Эрхзүйн Чөлөөт Бүс**

МХХТ өндөр хөгжсөн олон улс орнууд хэт хуульчилсан эрхзүйн орчинтой тул тэдний хувьд судалгаа, хөгжүүлэлт хийх орон зай дутмаг байдаг. Монгол Улс энэхүү боломжийг ашиглан, уул уурхай, хөдөө аж ахуй, боловсрол, роботик, финтек болон эрүүл мэндийн технологийн салбаруудад дэлхийн түвшний томоохон технологийн компаниуд өөрсдийн дата төвөө байгуулах, судалгаа шинжилгээг хууль эрхзүйн орчны ямар нэг дарамтгүйгээр явуулах бүс болж, түүнчлэн дотоодынхоо хүний нөөцийг сурган, дэлхийн технологиос суралцаж, эдийн засгаа сайжруулах, татварын орлогыг нэмэгдүүлэх бүрэн боломжтой юм.

Цахим эдийн засаг нь зөвхөн технологийн компаниудыг дэмжих явдал биш юм. Энэ нь одоо байгаа болон эдийн засгийн хувьд хамгийн их хувь нэмэр оруулж буй салбаруудыг илүү оновчтой болгож, эдийн засагт хамгийн өндөр үнэ цэнийг бий болгоход нь туслах явдал юм. Тиймээс АмЧам Монгол нь Монгол Улсын эдийн засаг ихээхэн хамаардаг уул уурхай, хөдөө аж ахуйн салбарт технологийн шинэчлэлийг стратегийн хувьд дэмжиж, боловсролын технологи (EdTech), эмнэлгийн технологи (MedTech), санхүүгийн технологи (FinTech)-ийг мөн хамтад нь хөгжүүлэх хэрэгтэй гэж үзэж байна.

- i) **Цахим гарын үсгийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх, төр, хувийн хэвшил, хууль сахиулах байгуулагууд, нотариатын газруудыг цахим гарын үсэг болон цахим тамгыг ашиглахыг зөвшөөрдөг болох шаардлагатай байна.** Хэдийгээр сүүлийн үед улсын бүртгэл, нийгмийн даатгал, тендер зэрэг төрийн үйлчилгээг цахимжуулж буй зарим нэг дэвшил байгаа боловч гэрээний хүчин төгөлдөр байдал, шүүхийн процесс гээд хуулийн бичиг баримтын хувьд Монгол улс бүхэлдээ цаасан тогтолцоотой билээ.